



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар Д/247

Хэрлэн сум

“Зудын хариу үйлдэл төсөл”-ийг аймгийн
хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн зөн Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Зудын хариу үйлдэл төсөл”-ийг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай :

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн
дарга:

“Дэлхийн зөн монгол олон улсын байгууллагын
Бор-өндөр 2 хөтөлбөр”-ийн менежер

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
дарга

Мал эмнэлгийн газрын дарга

Онцгой байдлын газрын дэд дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

“Дэлхийн зөн монгол олон улсын байгууллагын
Бор-өндөр 2 хөтөлбөр”-ийн хөгжлийн чиглүүлэгч

2. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн дарга буюу аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\Захирамж-2023

231010647